

**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС
ИЛТГЭХ ХУУДАС**

**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ**

2025 оны 06 дугаар сарын 30

Багахангай дүүрэг

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайланд тусгагдсан зорилт арга хэмжээ үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх үр дүн хангалтгүй болон үр дүн гараагүй арга хэмжээг тодруулах, эрчимжүүлэх, удирдлагуудыг мэдээ мэдээллээр хангах, дүгнэлт зөвлөмж гаргаж ажил сайжруулахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 206 дугаар тогтоолын 6.7-д “Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлал, байгууллагын ил тод байдлын хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг тус тус баримтална” гэж заасны дагуу бодлогын баримт бичиг үнэлэх аргачлалын дагуу үнэлэв.

Төлөвлөгөөний хүрээнд 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 23 зорилт, 85 арга хэмжээ төлөвлөгдсөнийг хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй нь харьцуулан үнэлэв.

Хэрэгжилт, хүрэх түвшин нь тодорхойгүй зарим ажлыг хариуцан гүйцэтгэгчээс нь асуулгын аргаар мэдээлэл цуглуулж, гүйцэтгэлийн тайланд нэмж оруулав.

Нэмэлт мэдээлэл шаардлагатай ажлуудын тайлан мэдээг хариуцан хэрэгжүүлэгч хэлтэс, мэргэжилтнүүдээс авч дүн шинжилгээ хийв.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн 23 зорилтын 85 арга хэмжээний биелэлтэд 2025 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 77.1 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв. Үүнд:

- “Үр дүнтэй” буюу 100 хувьтай - 6 зорилт;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хүртэл хувьтай - 61 зорилт;
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 31-69 хүртэл хувьтай - 4 зорилт;
- “Үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувьтай - 14 зорилт;
- “Хугацаа болоогүй” арга хэмжээ байхгүй байна.

ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ
(2025 оны хагас жилийн байдлаар)

(Үнэлгээний хүснэгт-1)

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО (7 Зорилт 14 арга хэмжээ)							
№	Бүлгийн нэр	Зорилт тоо	ХЭРЭГЖИЛТ				Үнэлгээ хувь
			Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (70-99)	Эрчимжүүлэх шаардлагатай (31-69)	Үр дүнгүй (0-30)	
1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3	-	2	-	1	70
2	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх	2	-	2	-	-	90
3	Боловсролын байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, сургалтын таатай орчныг бүрдүүлнэ.	2	-	2	-	-	90
4	Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.	1	-	1	-	-	90
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин зорилтот бүлгийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2	-	-	-	2	30
6	Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	-	1	-	-	90
7	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангана.	3	-	3	-	-	90
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО (7 зорилт 13 арга хэмжээ)							
8	Нийслэлийн төсвийн бус санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	3	-	3	-	-	90
9	Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийг иргэдэд нээлттэй мэдээлэх, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.	3	1	1	-	1	70
10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, үр дүнтэй зарцуулах.	2	-	2	-	-	90
11	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, төсөв, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах	1	-	1	-	-	90
12	Бизнесийн орчин буюу үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, гадаад дотоодын хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж ажлыг байрыг нэмэгдүүлнэ.	1	-	1	-	-	70
13	Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж, мал сүргийг эрүүлжүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангана.	1	-	-	-	1	30
14	Орон нутгийн брэнд, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	2	1	-	-	1	70
ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО (4 зорилт 27 арга хэмжээ)							
15	Хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх, хариуцлагатай, мэргэшсэн төрийн албан хаагчдыг бүрдүүлнэ	19	2	14	-	3	90
16	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах, нэгдсэн системийг нэвтрүүлэх	2	-	2	-	-	90


17	Архивын үйл ажиллагааг тогтолжуулах, баримтын ашиглалт хадгалалт хамгаалалтыг сайжруулах	3	-	3	-	-	90
18	Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг иргэдийн оролцоотой, сурталчлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана	3	-	3	-	-	90
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО (1 зорилт 7 арга хэмжээ)							
19	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх оновчтой менежментийг нэвтрүүлэн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэн иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	7	2	2	-	3	70
ТАВ. ДУЛААН, ЦАХИЛГААН ХАНГАМЖ, ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ (1 зорилт 7 арга хэмжээ)							
20	Дэд бүтцийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэн, найдвартай байдлыг хангаж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	7	-	3	3	1	70
ЗУРГАА.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (1 зорилт 1 арга хэмжээ)							
21	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох, дамжуулах, мэдээллээр хангах үйл ажиллагааг сайжруулна.	1	-	1	-	-	70
ДОЛОО. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (1 зорилт 4 арга хэмжээ)							
22	Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлнэ	4	-	2	1	1	70
НАЙМ“ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ” ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (1 зорилт 11 арга хэмжээ)							
23	Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.	11	-	11	-	-	90
“Бүрэн хангалттай”		85	6	61	4	14	77.1%

ДӨРӨВ. ШИНЖИЛГЭЭ

Үр дүнтэй: Хагас жилийн байдлаар 85 арга хэмжээний 6 буюу нийт ажлын 7.1% нь “Үр дүнтэй” хэрэгжсэн. Зорилт арга хэмжээ нь оновчтой, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүнд хүрсэн ажлууд байна.

Тодорхой үр дүнд хүрсэн: Нийт зорилтын 61 буюу 71.7 % нь “Тодорхой үр дүнд хүрсэн” байна. Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтод түвшиндээ бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүнд гарч эхэлсэн, хэрэгжилт үр дүнд нэмэгдүүлэх шаардлагатай.

Эрчимжүүлэх шаардлагатай: Нийт зорилтын 4 буюу 4.7% нь “Эрчимжүүлэх шаардлагатай” шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.



Үр дүнгүй: Нийт зорилтын 14 буюу 16.4% нь “Үр дүнгүй”, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй байна. Хугацаа болоогүй арга хэмжээ байхгүй байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

1. 2025 оны хагас жилийн байдлаар Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувьтай хэрэгжсэн 4 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувьтай 14 арга хэмжээг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган эрчимжүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай;

2. Биелэлт гаргаж байгаа мэргэжилтнүүд байгууллагын гүйцэтгэлийн тайланг төлөвлөгөөнд тусгасан хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу товч бөгөөд тодорхой 2000 тэмдэгтэд багтаан тайлагнахад анхаарах;

31-69 ХҮРТЭЛ ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ 4 АРГА ХЭМЖЭЭ

Арга хэмжээ-5.1.5. Өндөртолгой хотхоны хойд жигүүрийн халаалт, хэрэглээний шугам шинэчилнэ.

Арга хэмжээ-5.1.6. Дүүргийн 1 дүгээр хорооны нийтийн зориулалттай орон сууцны 2, 6 дугаар байрны хэрэглээний халуун ус болон цэвэр усны босоо шугам солино.

Арга хэмжээ-5.1.7. Дүүргийн халаалтын зуухны яндангуудад утааны шүүлтүүр суурилуулна.

Арга хэмжээ-7.1.3. Хүнсний хангамж аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг хангаж ажиллана.

0-30 ХҮРТЭЛ ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ 14 АРГА ХЭМЖЭЭ

Арга хэмжээ-1.1.3. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг

Арга хэмжээ-1.5.1. Зорилтот бүлгийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх

Арга хэмжээ-1.5.2. Ахмад настны мэргэжлийн ур чадвар, ажлын туршлагад суурилсан зөвлөн туслах, үйлчилгээнд хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх

Арга хэмжээ-2.2.1. Орон нутгийн сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс цахим хэлбэрээр буюу гар утасны аппликейшн ашиглан авах.

Арга хэмжээ-2.6.1. Малыг эрүүлжүүлэх, чанар, үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж малчдыг нэгтгэн “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг өрнүүлнэ.

Арга хэмжээ-2.7.2. Дүүрэгт худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг бий болгож, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.

Арга хэмжээ-3.1.1. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг дээшлүүлэн, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлнэ

Арга хэмжээ-3.1.6. “Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ

Арга хэмжээ-3.1.14. Онцгой байдлын байгууллагуудын нэгдсэн “Нэгдсэн бэлтгэл сургалтын төв”-ийг бэлтгэл ажлыг хангана

Арга хэмжээ-4.1.4. Иргэдийн амьдрах орчныг сайжруулан, орчны болон хөрсний бохирдол, доройтлыг бууруулж, эко системийн тэнцвэртэй байдлыг хангана

Арга хэмжээ-4.1.6. Усны шинэ үүсвэрийг тусгай хамгаалалтад авч хашаажуулах ажлыг эхлүүлнэ.

Арга хэмжээ-4.1.7. Бэлчээрийн доройтлыг арилгах, экологийн тэнцвэрт байдлыг хангаж, цөлжилтэй тэмцэх ажлуудыг зохион байгуулна.

Арга хэмжээ-5.1.2. Нуур, Замчин гэр хорооллын Дэд бүтцийн төв”-ийн гадна инженерийн хангамж, шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлнэ.

Арга хэмжээ-7.1.4. Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын 4-р (Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой

тэнцвэрийг хангах зорилгоор Багахангай дүүргийн хүн амыг 20 хувиар нэмэгдүүлэх)
заалтын хэрэгжилтийг хангана.

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОТГОНЖАРГАЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЦЭНГЭЛ